



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 2/11

Мандалговь


Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.6, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын “Эрүүл хот-Эрүүл өрх” дэд хөтөлбөрийн хүрээнд хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх дасгал хөдөлгөөн хийх арга хэмжээг 2020 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн хавсралт хуваарийн дагуу тогтмол явуулсугай.

2.Албан хаагчдыг хуваарийн дагуу дасгалыг тогтмол хийлгэж, хяналт тавин бүртгэхийг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Х.Дашням), Нарлаг багийн нийгмийн ажилтан (Э.Мөнхжаргал) нарт даалгасугай.

3.Зохион байгуулж байгаа арга хэмжээнд идэвхтэй оролцохыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ОЮУНЧИМЭГ